


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2025 оны эхний 5 сарын дүнгээр гадаад худалдааны нийт бараа эргэлт **9,964.7** сая ам.доллар болж 2024 оны мөн үеэс 786.5 сая ам.доллар буюу 7.3 хувиар буурчээ. Экспортын дүн импортын дүнгээс 884.5 сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа.

Гадаад худалдааны бараа эргэлт буурсан нь манай улсын нийт экспорт саарсан, гол экспортод гарч байгаа түүхий эдийн үнэ буурсан нь нөлөөлжээ.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт /сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 5 сар				Өөрчлөлт	
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	7,221.0	9,768.6	10,751.1	9,964.7	-786.5	-7.3
-Экспорт	4,083.7	6,305.8	6,356.0	5,424.6	-931.4	-14.7
-Импорт	3,137.3	3,462.9	4,395.2	4,540.1	144.9	3.3
Тэнцэл	946.5	2,842.9	1,960.8	884.5	-1,076.3	-54.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **884.5** сая ам.долларын ашигтай гарсан байна. Тэнцэл өмнөх оны мөн үеэс 1,076.3 сая ам.доллараар буурахад **экспорт 931.4 сая ам.доллараар буурсан** нь голлон нөлөөлсөн байна.

Экспорт: 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр экспорт **5,424.6** сая ам.доллар болж, 2024 оны мөн үетэй харьцуулахад 931.4 сая ам.доллар буюу 14.7 хувиар буурсан байна.

Импорт: 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр импорт **4,540.1** сая ам.доллар болж, 2024 оны мөн үетэй харьцуулахад 144.9 сая ам.доллар буюу 3.3 хувиар өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Монгол Улс дэлхийн 66 оронд бараа экспортолноос БНХАУ-д 91.8 хувь, Швейцар-т 5.3 хувь, АНУ-д 0.9 хувь, ОХУ-д 0.5 хувь тус тус ногдож нийт экспортын 98.5 хувийг дээрх орнууд эзэлж байна.

Нийт экспортын 89.1 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 10.9 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **4,834.5** сая ам.доллар болж, өмнөх оноос 846.8 сая ам.доллар буюу 14.9 хувиар буурсан бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **590.1** сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 84.5 сая ам.доллар буюу 12.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 5 сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	3,384.9	5,492.4	5,681.3	4,834.5	-846.8	-14.9	89.1
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	698.8	813.4	674.7	590.1	-84.5	-12.5	10.9
Нийт экспорт	4,083.7	6,305.8	6,356.0	5,424.6	-931.4	-14.7	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Нийт экспортын орлогын дийлэнх хувийг эрдсийн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа тул тус бүтээгдэхүүний үнийн уналт нь манай улсын эдийн засгийн өсөлт, төсвийн орлогод сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд эрдсээс бусад салбаруудын экспортын хувь хэмжээ бага, бууралт өндөр байгаа нь экспортын төрөлжилт хангалтгүй байгааг харуулж байна.

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 44.4 хувийг нүүрс, 36.0 хувийг зэсийн баяжмал, 6.4 хувийг боловсруулаагүй алт, 4.3 хувийг төмрийн

хүдэр, 3.1 хувийг жоншны баяжмал, 2.1 хувийг боловсруулаагүй нефть, 1.8 хувийг цайрын баяжмал тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Эхний 5 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2024	2025	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	643.1	852.1	209.0	32.5
Нүүрс	сая.тн	32.5	31.8	-0.8	-2.3
Төмрийн хүдэр	сая.тн	3.0	3.1	0.1	5.0
Цайрын баяжмал	мян.тн	49.4	60.9	11.5	23.3
Алт	тн	4.7	3.4	-1.3	-27.8
Түүхий нефть болон газрын тос	сая.баррель	1.8	1.5	-0.3	-16.6
Катодын зэс	мян.тн	5.5	5.4	0.0	-0.7
Жоншны баяжмал	мян.тн	462.2	659.2	196.9	42.6
Адууны мах	мян.тн	3.5	5.3	1.8	53.5
Өлөн гэдэс	тн	226.8	527.2	300.4	132.5
Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	19.0	0.5	-18.5	-97.4
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	183.6	24.8	-158.7	-86.5
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	0.0	1.4	1.3	1,124,900.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	20.2	9.0	-11.2	-55.4
Ямааны самнасан ноолуур	тн	220.0	152.9	-67.1	-30.5
Ямааны угаасан ноолуур	тн	1,107.3	-	-1,107.3	-100.0
Самнаагүй хонины ноос	мян.тн	1.8	1.2	-0.6	-34.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	Эхний 5 сар		Өмнөх оны мөн үеэс		Экспортод эзлэх хувь
	2024	2025	Дүн	Хувь	
Зэсийн баяжмал	1,151.0	1,852.8	701.8	61.0	36.0
Нүүрс	3,855.0	2,283.4	-1,571.6	-40.8	44.4
Төмрийн хүдэр	237.4	221.1	-16.2	-6.8	4.3
Цайрын баяжмал	66.4	94.0	27.6	41.5	1.8
Алт	332.6	330.6	-2.0	-0.6	6.4
Түүхий нефть болон газрын тос	141.1	110.0	-31.1	-22.0	2.1
Катодын зэс	46.5	49.0	2.5	5.4	1.0
Жоншны баяжмал	101.5	159.2	57.7	56.8	3.1
Адууны мах	12.2	18.7	6.5	53.6	0.4
Өлөн гэдэс	4.3	6.2	1.9	44.3	0.1
Үхэр, адууны боловсруулсан шир	0.4	0.0	-0.4	-97.2	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.4	0.0	-0.4	-95.6	0.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.0	0.0	0.0	13,400.0	0.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	0.6	0.2	-0.4	-70.9	0.0
Ямааны самнасан ноолуур	22.1	15.9	-6.1	-27.8	0.3
Ямааны угаасан ноолуур	60.7	-	-60.7	-100.0	-
Самнаагүй хонины ноос	2.0	1.3	-0.7	-32.9	0.0
Нийт экспортод эзлэх хувь	94.9	94.8			94.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 5. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүний үнэ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Эхний 5 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2024	2025	Дүн	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	120.6	74.9	-45.6	-37.8
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,789.6	2,174.3	384.7	21.5
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	80.2	71.2	-9.1	-11.3
Цайрын баяжмал	тн/ам.дол	1,344.2	1,543.4	199.2	14.8
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	219.6	241.5	21.8	9.9
Молибдены баяжмал	тн/ам.дол	15,034.1	15,935.0	900.9	6.0
Алт	кг/ ам.дол	70,215.8	96,625.6	26,409.8	37.6

Эх сурвалж: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

Эрдсийн бүтээгдэхүүний экспортод голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Нүүрс: 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр **2,283.4** сая ам.долларын **31.8** сая.тн нүүрс экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 1,571.6 (40.8%) сая ам.доллар, биет хэмжээ 0.8 (2.3%) сая.тн-оор тус тус буурсан. Нүүрсийг 100 хувь БНХАУ руу экспортолсон. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ **74.9** ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 45.6 ам.доллар буюу **37.8 хувиар буурчээ**.

Зэсийн баяжмал: 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр **1,852.8** сая ам.долларын **852.1** мян.тн зэсийн баяжмал экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 701.8 (61.0%) сая ам.доллар, биет хэмжээ 209.0 (32.5%) мян.тн-оор тус тус өссөн. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон. Нэг тонн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ **2,174.3** ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 384.7 ам.доллар буюу **21.5 хувиар өссөн** байна.

Алт: 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр **330.6** сая ам.долларын **3.4** тн алт экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 2.0 сая ам.доллар буюу 0.6 хувиар, биет хэмжээ 3.4 тн буюу 27.8 хувиар тус тус буурсан. Нэг кг алтны экспортын дундаж үнэ **96,625.6** ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс **26,409.8** ам.доллар буюу 37.6 хувиар өссөн. Алтны 84.2 хувийг Швейцар, 14.7 хувийг АНУ руу тус тус экспортолсон.

Төмрийн хүдэр, баяжмал: 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр **221.1** сая ам.долларын **3.1** сая.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 16.2 (6.8%) сая ам.доллараар буурч, биет хэмжээ 0.1 (5.0%) мян.тн-оор өссөн. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон. Нэг тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ **71.2** ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 9.1 ам.доллар буюу 11.3 хувиар буурчээ.

Цайрын баяжмал: 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр **94.0** сая ам.долларын **60.9** мян.тн цайрын баяжмал экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 27.6 (41.5%) сая ам.доллар, биет хэмжээ 11.5 (23.3%) мян.тн-оор тус тус өссөн. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон. Нэг тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ **1,543.4** ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 199.2 ам.доллар буюу 14.8 хувиар өссөн.

Газрын тосны экспорт: 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 110.0 сая ам.долларын 1.5 сая.бар газрын тос экспортолсон. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 31.1 (22.0%) сая ам.доллар, биет хэмжээгээр 0.3 (16.6%) сая.бар-иар тус тус буурсан. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон.

- Эрдэс баялгийн экспортын орлого, зах зээл (ялангуяа БНХАУ)-ын нөхцөл байдлаас хамаарч савлаж байна.
- Зэс, жонш, цайрын экспорт нэмэгдэж буй нь эерэг үзүүлэлт юм.
- Нүүрс, газрын тос, алтны экспортын бууралт нийт экспортод болон Монгол Улсын төсвийн орлогод сөргөөр нөлөөлж байна.
- Монгол Улсын экспортын бүтэц хязгаарлагдмал, эрсдэлтэй хэвээр байна.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Манай Улс дэлхийн 137 орноос гарал үүсэлтэй бараа импортолсноос БНХАУ-д 36.7 хувь; ОХУ-д 24.3 хувь; Япон-д 13.2 хувь; БНСУ-д 4.3 хувь; АНУ-д 4.2 хувь тус тус ногдож байгаа нь нийт импортын дүнгийн 82.6 хувийг эзэлж байна.

Нийт импортын 21.0 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 79.0 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **951.4** сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 75.8 сая ам.доллараар буюу 7.4 хувиар буурсан байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **3,588.7** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 220.7 сая ам.доллар буюу 6.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 6. Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 5 сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	677.9	834.8	1,027.1	951.4	-75.8	-7.4	21.0
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	2,459.4	2,628.0	3,368.0	3,588.7	220.7	6.6	79.0
Нийт импорт	3,137.3	3,462.9	4,395.2	4,540.1	144.9	3.3	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги 23.0 хувь, мал амьтан, эрдэс бүтээгдэхүүн 21.0 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн

сэлбэг 20.3 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 8.3 хувь, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 7.6 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Эхний 5 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2024	2025	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	52.1	56.7	4.6	8.8	1.2
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	84.1	72.4	-11.7	-13.9	1.6
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	16.0	21.0	4.9	30.8	0.5
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	317.4	346.8	29.4	9.3	7.6
5	Эрдэс бүтээгдэхүүн	1,027.1	951.4	-75.8	-7.4	21.0
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	230.8	249.0	18.2	7.9	5.5
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	144.5	144.2	-0.3	-0.2	3.2
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	3.8	3.5	-0.3	-8.2	0.1
9	Мод, модон эдлэл	37.9	47.6	9.7	25.7	1.0
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	32.9	28.7	-4.2	-12.8	0.6
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	49.0	45.8	-3.2	-6.5	1.0
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	15.3	16.2	0.9	6.1	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	87.6	90.5	2.9	3.4	2.0
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	1.7	1.8	0.0	2.6	0.0
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	360.3	377.5	17.2	4.8	8.3
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	927.3	922.8	-4.5	-0.5	20.3
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	902.3	1,043.7	141.3	15.7	23.0
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	50.9	62.7	11.7	23.1	1.4
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	52.9	56.1	3.1	5.9	1.2
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.0	0.1	0.1	1,100.3	0.0
21	Бусад	1.1	1.7	0.7	61.7	0.0
	ДҮН	4,395.2	4,540.1	144.9	3.3	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импорт голлон нөлөөлсөн бараа, бүтээгдэхүүн

Суудлын автомашин импорт:

Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин **55,983** ширхэг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,445 ширхэг буюу 10.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 3,319 ширхгээр, бусад суудлын автомашин 2,126 ширхгээр тус тус өссөн.

Хүснэгт 8. Суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Барааны төрөл	Тоо хэмжээ		Өөрчлөлт		Татварын дүн		Өөрчлөлт	
	2024.05	2025.05	Дүн	Хувь	2024.05	2025.05	Дүн	Хувь
Хос тэжээлт	42,288	45,607	3,319	7.8	325	396	70.2	21.6
Бусад	8,250	10,376	2,126	25.8	122	191	69.4	57.1
Нийт	50,538	55,983	5,445	10.8	447	587	139.6	31.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Автобензин, дизелийн түлшний импорт:

Монгол Улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2025 оны эхний 5 сард **1,034.6** мян.тн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

Хүснэгт 9. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Төрөл	Барааны төрөл	Тоо хэмжээ /мян.тн/		Өөрчлөлт		Ногдуулсан татварын дүн		Өөрчлөлт	
		2024.05	2025.05	Дүн	Хувь	2024.05	2025.05	Дүн	Хувь
Автобензин	A-80	2.6	0.3	-2.3	0.1	1	0.1	-0.95	0.1
	A-92	347.9	322.3	-25.55	0.93	94.2	88.9	-5.32	0.94
	A-95 болон түүнээс дээш	10.7	6.7	-3.97	0.63	7.7	4.6	-3.16	0.59
Дизель түлш		667.5	705.3	37.85	1.06	272.9	267.4	-5.48	0.98
Нийт		1,028.7	1,034.6	6.0	2.7	375.8	361.0	-14.9	2.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гаалийн байгууллага нь 2025 оны эхний 5 сард нийт **2,952.1** тэрбум төгрөг төвлөрүүлэхээс **2,732.4** тэрбум төгрөг төвлөрүүлж, орлогын гүйцэтгэл **92.6** хувьтай байна. Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 212.8 тэрбум төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 10. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024.05	2025.05		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Орлогын биелэлтийн хувь
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Хувь
Нийт орлого	2,519.6	2,952.1	2,732.4	212.8	8.4	92.6
Татварын дүн	2,455.4	2,888.2	2,668.3	212.9	8.7	92.4
Гаалийн албан татвар	661.4	821.0	721.3	59.9	9.0	87.9
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,472.4	1,763.2	1,573.1	100.7	6.8	89.2
Архи, дарсны онцгой албан татвар	20.7	23.5	23.6	2.9	13.8	100.4
Тамхины онцгой албан татвар	55.4	48.9	57.5	2.1	3.8	117.6
Шар айргийн онцгой албан татвар	3.8	4.3	7.3	3.5	90.1	169.8
Суудлын автомашины онцгой албан татвар	229.0	202.4	274.2	45.2	19.7	135.5
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	2.0	8.8	1.4	-0.6	-30.0	15.9
Автобензин, дизель түлшний албан татвар	10.5	16.1	9.9	-0.6	-6.1	61.5
Экспортын татвар	0.0	0.0	-	0.0	-100.0	0.0
Хураамж	59.6	56.0	56.8	-2.8	-4.7	101.4
Өөрийн орлого	4.6	7.9	7.3	2.7	58.7	92.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэл өсөхөд нөлөөлсөн орлого:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар 100.7 тэрбум;
- Гаалийн албан татвар 59.9 тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар 45.2 тэрбум төгрөг;
- Шар айрагны онцгой албан татвар 3.5 тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар 2.9 тэрбум төгрөг;
- Өөрийн орлого 2.7 тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар 2.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин хураамжийн орлого 2.8 тэрбум төгрөг, автобензин, дизель түлшний онцгой албан татвар 0.6 тэрбум төгрөг, автобензин дизель түлшний албан татвар 0.6 тэрбум тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Тав. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Импортын бүтцийг харахад 2025 оны эхний 5 сард татвараас чөлөөлөгдсөн импорт **735.7** тэрбум төгрөгт хүрч, нийт импортын **4.7** хувийг эзэлж байна. Татвараас чөлөөлөгдсөн импортыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 121.9 тэрбум төгрөг буюу 14.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний 5 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2024	2025	Дүн	Хувь	
Татвартай импорт	13,951.1	14,872.9	921.8	6.6	95.3
Татвараас чөлөөлөгдсөн импорт	857.6	735.7	-121.9	-14.2	4.7
Нийт импорт	14,808.7	15,608.6	799.9	5.4	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС